

ГУЙЛГЫН ЭЗЭН (Өгүүллэг)

ЛҮ ШҮНЬ

Би бургисан шороо гишгэлэн нурж шалбарсан өндөр хэрмийн ёроолоор сажилж байв. Бас хэдэн хүн мөр мөрөөрөө гэлдэрнэ. Зөөлөн салхи сэвэлзэхэд, өндөр хэрмийн дээгүүр цухуйсан модны хараахан хатаж шарлаагүй навчис бүхий гишүү мөчир, миний толгой дээр сэвэгнэн найгана.

Салхи хөдлөхөд дөрвөн зүг шороо тоос бужигналаа.

Тэгтэл дан хувцастай нэгэн жаал, надаас гуйлга гуйхыг ажваас тийм ч тамтагтаа тулсан баймааргүй, гагцхүү урд орж уруулаа унжуулан, ард гарч алгаа тосно!

Амнаас нь гарах үгс аашилж намбаганах төрх нь намайг зэвүүцүүлэв.

Үнэнхүү өрөвдөлтэй амьтан гуйлга гуйж буй нь хараахан биш тул би эс тоомсорлосонд, бүр ч ший наадамрахуу юм болгоод сүүлдэж ядан хоргоосонд нь миний бие тун ч аягүйцлээ.

Би гэлдэрсээр л мөн хэдэн хүн мөр, мөрөөрөө дөхсөөр л салхи хөдлөн шороо бужигнасаар л.

Мөн л дан хувцастай бас нэг жаал надаас гуйлга гуйв. Харахад тийм ч тартагтаа тулчихсан амьтан биш дэг. Гагцхүү хэлгүйн учир хоёр гараараа сүржиндэх нь зэвүүцэлтэй.

Дохиж зангахы нь хараад миний дургүй хүрэв. Үнэндээ сайхь гайхал хэлтэй боловч

зориуд хэлгүйтэж, гуйлга хийхийн бас нэг арга сүвэгчилсэн байж юун магад.

Би юу ч хайрлахгүй, тийм сэтгэл ч алгаа. Харин одоогоор гуйлгачингаас илүү дээр яваа тул ширэв татах, зэвүүцэх, өширхөх, үзэн ядахыг л хайрлах билээ.

Нурж шалбарсан хэрмээ даган гэлдэрсээр сэтрэхийд хүрвэл хэмхэрхий тоосго овоолоостой, хэрмийн дотор эль хуль.

Салхи сэвэлзэн хөдлөхөд, намрын жавар нимгэн дээл нэвт үлээж, дөрвөн зүгт гагцхүү тоос бужигнана.

Хожим сүүлд би чухам яаж гуйлга хийх вэ? Дуу, зүсээ хэрхэн гаргавал таарах вэ? Хэлгүйтэж маяглавал хөл гарынхаа хөдөлгөөнийг хэрхвэл зохилтой гэхчилэн бодов.

Хэдэн хүн, мөр мөрөө хөөсөөр л. Хожим хойтод хайр хишиг хүртэхгүй нь лав, тийм хувь заяагүй, зөвхөн гуйлгын эзний дээр даврагчийн жишүү харц, хүйтэн сэтгэл, өшрөх хонзонг л хүртэх буй заа.

Учир иймд хожим гагцхүү дув дуугүй, хайш яйшхан төрхөөр л гуйлга хийнэ! ... Адаглахад өчүүхэн ч юм олдох нь магад. Зөөлөн салхи хөдөлж түйрэн бужигнасаар л. Замаа хөөсөн хэдэн хүн гэлдэрсээр л тоос

Тоос оо.....

1924 оны 9 дүгээр сарын 24.